



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 03 сарын 08 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

VII ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын хурлыг 2021 оны 3 дугаар сарын 8-ны өдрийн 14:00 цагт Төрийн ордон дахь Их танхимд 92.5 хувийн ирцтэй хуралдуулав.

Хурлыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан даргалж, холбогдох шийдвэрийг гаргаж, үүрэг даалгавар өгөв.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Шуурхай штабыг шинэчлэн байгуулсантай холбогдуулан танилцуулга мэдээлэл;

*Шуурхай штабын дарга,
хурандаа Ж.Чүлтэмсүрэн,*

2. Нийслэлийн онцгой комиссоос авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар танилцуулга мэдээлэл;

*Нийслэлийн Засаг дарга бөгөөд
Улаанбаатар хотын захирагч,
Улсын онцгой комиссын гишүүн Д.Сумъяабазар,*

3. Коронавируст халдварын нөхцөл байдал, вакцинжуулалтын талаарх мэдээлэл;

*Эрүүл мэндийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн С.Энхболд,*

4. "Эрсдэлийн мэдээлэл харилцааны түр хороо"-ноос авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх мэдээлэл;

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хэвлэл мэдээлэл,
олон нийттэй харилцах албаны дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Ц.Ганзориг*

5. Шуурхай штабын үйл ажиллагааг бүрэн цахимжуулах, улсын хэмжээнд "CLIX GPS" системийн бүртгэлийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл;

*Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Б.Болор-Эрдэнэ*

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг: Нийслэлийн Засаг дарга бөгөөд
Улаанбаатар хотын захирагч,
Улсын онцгой комиссын гишүүн Д.Сумъяабазар.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Т.Гантулга.

Цагдаагийн ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа,
Улсын онцгой комиссын гишүүн Ж.Болд нарт.

1.1. "Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалтын шар түвшинд зарим хуулийн этгээдийн салбар чиглэлийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, шаардлагатай тохиолдолд хэсэгчилсэн хязгаарлалт хийх.

1.2. QR код байршуулаагүй, халдвар хамгааллын дэглэм, холбогдох дүрэм журам мөрдөөгүй аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зогсоох хүртэл арга хэмжээг авч ажиллах.

Хоёр: Гадаад харилцааны сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Б.Батцэцэг,
Сангийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Б.Жавхлан,
Эрүүл мэндийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн С.Энхболд нарт

2.1. Аймаг, нийслэлийн хэмжээнд вакцинжуулалтын арга хэмжээг аюулгүй, өргөн хүрээнд зохион байгуулж, эрсдэлт бүлгийн иргэн, хуулийн этгээд, үйл ажиллагаа нь тасралтгүй явагдах шаардлагатай аж ахуйн нэгж байгууллагуудын ажилтан, албан хаагчдыг 2021 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн дотор бүрэн хамруулах, вакцинжуулалтын өмнөх болон дараах эрүүл мэндийн зөвлөмж, тусламжийг иргэдэд тухай бүр шуурхай өгч ажиллах

Гурав: Аймаг, нийслэлийн Онцгой комиссын дарга,
Улсын онцгой комиссын шуурхай штабын дарга нарт

3.1. Шуурхай штабын шинэ бүтэц бүрэлдэхүүний үйл ажиллагааг жигдрүүлж, иргэдийн гомдол, саналыг тухай бүр шийдвэрлэн, хариуг өгөх арга хэмжээг шуурхай зохион байгуулах, хяналт тавьж ажиллах

Дөрөв: Улсын онцгой комиссын орлогч дарга,
Батлан хамгаалахын сайд, Г.Сайханбаяр,
Шадар сайдын зөвлөх П.Оюунчимэг нарт

4.1. Шуурхай штабын үйл ажиллагааны чиг үүрэг, хүний нөөцийг зохистой хуваарилж, дотоод зохион байгуулалтыг Улсын онцгой комиссоос гаргасан холбогдох шийдвэртэй уялдуулан зохицуулах.

Тав: Засагийн газрын Хэрэг эрхлэх газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй
харилцах албаны дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Ц.Ганзориг

5.1. "Эрсдэлийн мэдээлэл харилцааны түр хороо"-ны үйл ажиллагааг тогтмол тасралтгүй явуулах,

5.2. Коронавируст халдварын нөхцөл байдлын мэдээллийг иргэд, олон нийтэд ойлгомжтой тодорхой байдлаар боловсруулж, бүх төрлийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр шуурхай хүргэж, мэдээллийг нэг урсгалаар тогтмол түгээж ажиллах,

Зургаа, Зам тээврийн хөгжлийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Л.Халтар,
Аймаг, нийслэлийн Онцгой комиссын дарга нарт

6.1. Улсын онцгой комиссын шийдвэр, цаг үеийн нөхцөл байдлын талаар мэдээлэл хийхдээ урьдчилан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах газар, "Эрсдэлийн мэдээлэл харилцааны түр хороо"-той зөвлөлдөх,

6.2. Аймаг, нийслэлийн Онцгой комисс нутаг дэвсгэртээ эрсдэлийн үнэлгээ хийж, хот хоорондын зорчигч тээврийн хөдөлгөөний зохицуулалтыг шийдвэрлэх,

6.3. Худалдаа үйлчилгээний байгууллагын үйл ажиллагаанд цагийн зохицуулалт хийж, оройн цагаар шаардлагатай тохиолдолд цаг, хүний тоог хязгаарлах,

6.4. Олон нийтийг хамарсан хурал, цуглаан, урлаг соёлын тоглолт, спортын арга хэмжээ зохион байгуулахгүй байх.


Долоо, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Б.Болор-Эрдэнэ,
Тэгнүүлын ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн, хурандаа П.Одонбаатар,
Харилцаа холбооны зохицуулах түр хорооны дарга Г.Чинзориг,
Шуурхай штабын дарга, хурандаа Ж.Чултэмсүрэн нарт

7.1. Улсын онцгой комиссын Шуурхай штабын үйл ажиллагааг бүрэн цахимжуулж, мэдээллийн нэгдсэн програм, системтэй болгох, бүх шатны шуурхай штаб, холбогдох байгууллагууд мэдээлэл шуурхай солилцох, техник технологийн нөхцлийг бүрдүүлж, мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллах.

Найм, Эрүүл мэндийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн С.Энхболдод

8.1. Вакцинжуулалтын ажлыг эрчимжүүлж, тандалтын багийн үйл ажиллагааг өргөтгөн, хүн хүч нэмж ажиллуулах, үндэсний хэмжээнд молекул лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, оношлуурын нөөцийг бүрдүүлэх, тандалт судалгааны хэлбэрийг шинэчлэн зохион байгуулах

ДАРГА



САМАРСАЙХАН

ОРЛОГЧ ДАРГА,

БРИГАДЫН ГЕНЕРАЛ

Г.АРИУНБУЯН